

БАТЛАВ
АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ /С/ М.МОНХӨӨ

УЛААНБААТАР ХОТ
ЭРЧИМ ДӨЛ ХХК-ИЙН ЗАХИРАЛ
Л.НАРАНБААТАР

G- 250 МАРКИЙН КОМПРЕССОРЫН СЭЛЬЭГ, ХЭРЭГСЭЛ ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ

Дугаар № ..1023/68

2023 оны 10-р сарын 28
өдөр

Улаанбаатар хот

Нэг талаас “АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ” Төрийн өмчийт хувьцаат компани /цаашид “Захиалагч” гэх/-ийг төлөөлж Гүйцэтгэх захирал М.Мөнхөө нөгөө талаас “Эрчим дөл” ХХК-ийг төлөөлж захирал Л.Наранбаатар /цаашид “Нийлүүлэгч” гэх/ нар Монгол Улсын Иргэний хуулийн 343-358 дугаар зүйл, Төрийн болон Орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.4.3 дах заалт, 34 дүгээр зүйлийн 34.1.5 дах заалт, Амгалан дулааны станц ТӨХК-ийн үнэлгээний хорооны 07 дугаар сарын 03-ны №2 тоот хурлын шийдвэр, зөвлөмж 2023 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тус тус үндэслэн дараах зүйлүүдийг харилцан тохиролцож энэхүү гэрээг (цаашид “гэрээ”гэх) байгуулав.

Нэг. Гэрээгээр нийлүүлэх зүйл, нөхцөл

1.1. Нийлүүлэгч нь “G-250 маркийн компрессорын сэлбэг, хэрэгсэл” (цаашид “бараа” гэх)-ыг энэхүү гэрээний салшгүй хэсэг болох хавсралтанд заасан барааг нэр төрөл, нэг бүрийн үнэ, техникийн үзүүлэлт, стандартын дагуу “Амгалан дулааны станц” ТӨХК-ийн агуулахад нийлүүлнэ.

Хоёр. Бараа нийлүүлэх хугацаа

2.1. Нийлүүлэгч нь барааг гэрээнд хоёр тал гарын үсэг зурж баталгаажуулснаас хойш 30 /гуч/ хоногийн дотор нийлүүлнэ.

Гурав. Үнэ төлбөрийн нөхцөл

3.1. Энэ гэрээний нийт үнэ 94,921,200 /ерэн дөрвөн сая есөн зуун хорин нэгэн мянга хоёр зуу/-н төгрөг бөгөөд үнийн дунд гааль Онцгой албан татвар, “Амгалан дулааны станц” ТӨХК-ийн агуулахад хүргэх тээврийн зардал НӨАТ бүгд шингэсэн байна.
3.2. Захиалагчаас нийлүүлэгчид урьдчилгаа төлбөр төлөхгүй.
3.3. Барааг хүлээлгэн өгсөний дараа бараа хүлээн авсан акт, гэрээ дүгнэсэн акт баталгаажсанаас хойш 30 /гуч/ хоногийн дотор төлбөрийг нэхэмжлэлийн дагуу нийлүүлэгчийн Худалдаа хөгжлийн банк 420000777 тоот дансанд шилжүүлнэ.

Дөрөв. Талуудын хүлээх хариуцлага

4.1. Нийлүүлэгч нь гэрээний үүргээ зохих ёсоор биелүүлээгүй, хугацаандaa нийлүүээгүй барааны нийт үнийн дүнгийн 0.1 хувьтай тэнцэх алдангийг захиалагчид хоног тутам төлөх ба нийт алдангийн үнийн дун гэрээний нийт үнийн дүнгийн 10% -иас хэтрэхгүй байна.
4.2. Захиалагч нь барааны бүрэн бүтэн байдал, техникийн үзүүлэлт, шаардлагад тохирч байгаа эсэхийг шалган үзээд хүлээн авсаны дараа гэрээнд заасан хугацаанд тооцоо

1/4

Захиалагч

М.Н.

Нийлүүлэгч

- хийх, төлбөрийн хугацааг хожимдуулбал хожимдсон хоног тутамд хүлээгдэж байгаа төлбөрийн 0.1 хувьтай тэнцэх алдангийг Нийлүүлэгчид төлөх ба алдангийн дүн нь гэрээний хүлээгдэж байгаа төлбөрийн үнийн дүнгийн 10% хувиас хэтрэхгүй байна.
- 4.3. Барааг Амгалан дулааны станц ТӨХК-ийн агуулахад ирсэний дараа тус компанийн бараа хүлээн авах комисс шаардлага хангаж байгааг тогтоосон тохиолдолд барааг хүлээн авна. Барааг шаардлага хангаагүй тохиолдолд буцаана.
- 4.4. Захиалагчийг төлөөлж гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудлыг “Амгалан дулааны станц” ТӨХК-ийн Зухан цехийн дарга Э.Ариунболд хариуцан ажиллана. Утас-89000800.
- 4.5. Нийлүүлэгчийг төлөөлж гэрээтэй холбоотой асуудлыг Эрчим дөл ХХК-ийн Ерөнхий инженер М.Хишигжаргал хариуцан ажиллана. Утас- 88248185.

Тав. Бараа бүтээгдэхүүний чанар, сав, баглаа, боодол

- 5.1. Нийлүүлэгчийн нийлүүлэх бараа нь Олон улсын болон Монгол улсын стандарт шаардлагыг бүрэн хангасан байна.
- 5.2. Бараа нь тээвэрлэлт, хадгалалтын үед норох, гоожихоос хамгаалсан сав, баглаа боодлой байна.
- 5.3. Барааг захиалагчид хүлээлгэн өгөх үед энэхүү гэрээгээр тодорхойлсон шинж чанарт нийцэж байвал зохих бөгөөд цаашид технологийн горим, зориулалтын дагуу ашиглах хугацаанд чанараа алдахгүй байх ёстой.
- 5.4. Нийлүүлсэн бараанд ямар нэгэн дутагдал, шаардлагад нийцээгүй бараа илэрвэл дутагдлыг арилган, сольж өгөхийг Захиалагч шаардах ба нийлүүлэгч шаардлагыг биелүүлэх үүрэгтэй.
- 5.5. Нийлүүлэгч нь нийлүүлсэн барааг угсарч сууринуулаж өгнө.
- 5.6. Компрессорын ажиллагаанд 6 сарын баталгаа гаргана.
- 5.7. Нийлүүлэгчийн үйл ажиллагаатай холбогдон гарсан алдаа, доголдлыг өөрийн зардлаар засаж залруулах үүрэгтэй.

Зургаа. Бараа хүлээн авах

- 6.1. Нийлүүлэгч нь ачигдсан барааг Улаанбаатар хотын Амгалан дулааны станц ТӨХК-ийн агуулахад буулгаж, бараа хүлээн авах комисс хүлээн авна.
- 6.2. Нийлүүлэгч нь барааг Захиалагчид хүлээлгэн өгөх хүртэлх бүх зардлыг хариуцна.

Долоо. Давагдашгүй хүчин зүйл

- 7.1. Гэрээг хэрэгжүүлэх явцад улс төрийн хориг, байгалийн гамшиг, хорио цээр тогтоох, цэргийн үймээн, төрийн эргэлт, ажил хаялт болон бусад нөхцлүүд бий болсноос үүдэж гэрээний нөхцлүүд хэсэгчилэн болон бүрэн биелээгүй тохиолдолд хоёр талын аль нь ч хариуцлага хүлээхгүй.
- 7.2. Давагдашгүй хүчин зүйлийн нөхцөлүүд гарч эхэлсэн тохиолдолд 10 хоногийн дотор талууд бие биедээ бичгээр мэдээлж цаашид хэрхэн ажиллах талаар зөвшилцөнө.

Найм. Гэрээг цуцлах үндэслэл

- 1) Нийлүүлэгч нь бараа материал нийлүүлэх энэхүү гэрээнд зааснаас 30 хоног хэтрүүлсэн тохиолдолд Захиалагч гэрээг цуцлах тухай мэдэгдлийг нийлүүлэгчид албан ёсоор бичгээр өгнө. Нийлүүлэгч уг мэдэгдлийг хүлээн авснаас хойш 5 хоногийн дотор зохих хариуг өгч тодорхой арга хэмжээ аваагүй тохиолдолд захиалагч гэрээг цуцлах ба баталгааг буцаан олгохгүй.
- 2) Нийлүүлэгч энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ удаа дараа буюу ноцтой зөрчсөнөөс

бусад тохиолдолд Захиалагч энэхүү гэрээний үйлчлэлийг дуусахаас өмнө тасалдуулахгүй.

Ес. Бусад нөхцөл

- 9.1. Талуудын аль нэг нь нөгөөдөө гэрээтэй холбогдох мэдээлэл солилцох тохиолдолд мэдээллийг авсан тал хуанлийн 10 хоногт багтаан нөгөө талдаа тавьсан асуудлаар тодорхой хариу өгнө.
- 9.2. Талууд аль нэгнийхээ зөвшөөрөлгүйгээр энэхүү гэрээг гурав дахь талд шилжүүлэхийг хориглоно.
- 9.3. Гэрээг монгол хэл дээр 3 хувь үйлдэж, Захиалагч 3 хувийг Нийлүүлэгч 1 хувийг авах бөгөөд хувиуд ижил тэгш хүчинтэй.
- 9.4. Гэрээг хоёр тал зөвшөөрсөн тохиолдолд гэрээг нэг удаа сунгаж болно.
- 9.5. Гэрээнд хоёр тал гарын үсэг зурсан өдрөөс хүчин төгөлдөр болно.
- 9.6. Гэрээнд талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр бичгээр үйлдсэн гэрээний хэлбэрээр нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд нэмж засварласан эх хувьд баллаж засварласан буюу гараар нэмж бичсэн болон бусад энгийн аргаар хийсэн оруулга засвар нэмэлт бичилтийг хүчинтэйд тооцохгүй.
- 9.7. Энэхүү гэрээнд шууд заагаагүй бусад аливаа асуудлыг Монгол улсын хүчин төгөлдөр мөрдөж байгаа хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК-ИЙН

ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР
Э.МОНХЖАРГАЛ

A handwritten signature in blue ink, appearing to read "Erchim Dolkhai".

СЭЗХ-ИЙН ДАРГА БӨГӨӨД ЕРӨНХИЙ
НЯГТЛАН БОДОГЧ
Ө.УДВАЛ

A handwritten signature in blue ink, appearing to read "O.Udval".

АЖ АХҮЙ, ХАНГАМЖИЙН ХЭЛТСИЙН ДАРГА
Г.БАТТУЛГА

A handwritten signature in blue ink, appearing to read "G.Battulgaa".

ЗУХАН ЦЕХИЙН ДАРГА
Э. АРИУНБОЛД

A handwritten signature in blue ink, appearing to read "E.Arionbold".

ГЭРЭЭ БОЛОВСРУУЛСАН :
ХАНГАМЖИЙН МЭРГЭЖИЛТЭН
М.МОЛОМЖАВ

A handwritten signature in blue ink, appearing to read "M.Molomjav".

НИЙЛҮҮЛЭГЧИЙН ТОЛООЛЖ:

ЭРЧИМ ДӨЛХХК-ИЙН ЗАХИРАЛ

Л.НАРАНБААТАР



Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 8-р хороо, УС-15-1-1
Утасны дугаар: 77111251
РД: 6021646

Хаяг: Улаанбаатар-36, Хан-Уул дүүрэг, 15-р хоро Романа Резидиент, 606
РД: 5304393
Утас: 88248185

Захиалагч

A handwritten signature in blue ink, appearing to read "Zahiyalagch".

3/4

A handwritten signature in blue ink, appearing to read "Nийлүүлэгч".

Нийлүүлэгч